

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид "журам" гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй. Журмын 13.1-д заасны дагуу Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах тул уг тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Цэвээнсүрэн Ургийн овог: Чойном Нэр: Давхарбаяр Хүйс: Эм Төрсөн он: 1965 он Төрсөн газар: Улаанбаатар хот, СБД, 1 дүгээр төрх. Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот,
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний алинд нэр дэвших тухай хүсэл гаргасан талаар бичнэ. Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд.
Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга	
Сонгон шалгаруулалтын найман үе шат тус бүрийг журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.	
3	Нэгдүгээр үе шат Журмын 3.1.1-д заасны дагуу "сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх" үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус 5 гишүүнийг Монгол Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилохоор заасны дагуу 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл олон нийтэд нээлттэй зарлаж, холбогдох материалыг хүлээн авахаар Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолыг баталсан. Энэ тогтоолын дагуу

	сонгон шалгаруулалтын зарыг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийтэд мэдээлсэн.
4	<p>Хоёрдугаар үе шат Журмын 3.1.2-д заасны дагуу “нэр дэвших тухай хүсэлт гаргах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн. Тус хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нийт 59 хүн нэрээ дэвшүүлэн, холбогдох материалыг ирүүлснээс 1 хүн нэрээ татаж нийт 58 хүн нэр дэвших хүсэлт гаргасан.</p>
5	<p>Гуравдугаар үе шат Журмын 3.1.3-д заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.2-т “Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.” гэж заасан. Энэ талаар нарийвчилсан зохицуулалтыг Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д тусгасан.</p> <p>Дээрх заалтын дагуу Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 09, 10, 20 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын зөвлөх Д.Батдорж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч М.Баасанбат, Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан, “Шихихутуг” их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Г.Амаржаргалан нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.</p> <p>Тайлбар: Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Монголын Хуульчдын холбооны төлөөллийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд тус холбооноос Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбатын нэрийг ирүүлсэн тул Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай 10 дугаар тогтоолыг баталсан. Түүнчлэн МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга А.Бямбажаргалын албан үүрэг өөрчлөгдсөн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Саруул ажлаасаа чөлөөлөгдсөн тул</p>

	Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай 20 дугаар тогтоолоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.
6	<p>Дөрөвдүгээр үе шат Журмын 3.1.4-д заасны дагуу “нэр дэвшигчээр бүртгэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Ажлын хэсэг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан материалын шаардлагыг хангасан гэж үзэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 29 хүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд 24 хүнийг нэр дэвшигчээр бүртгэсэн. Ажлын хэсгийн энэхүү хуралдаанаар Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчээр бүртгэсэн.</p>
7	<p>Тавдугаар үе шат Журмын 3.1.5-д заасны дагуу “нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 8.1-д “нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ.” гэж заасны дагуу дээр дурдсан 53 нэр дэвшигчийн материалыг www.parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Хууль зүйн байнгын хорооны Ажлын алба нэр дэвшигч Ц.Давхарбаярын Нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн байршуулсан.</p>
8	<p>Зургадугаар үе шат Журмын 3.1.6-д заасны дагуу “нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно” гэж заасныг баримтлан 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж, илтгэгч гишүүнийг томилсон.</p>
9	<p>Долдугаар үе шат Журмын 3.1.7-д заасны дагуу “Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1-д “Энэ журмын 10.7-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.” гэж, 11.2-д “Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч</p>

	<p>даргална.” гэж заасан.</p> <p>Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 8, 9, 10-ны өдрүүдэд ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 29 хүн нэр дэвшсэнээс 3 хүн нэрээ татсан бол 1 хүний төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, 1 хүн ярилцлагад ороогүй тул бүртгэлээс хасаж нийт 24 хүнтэй ярилцлага зохион байгуулсан. Шүүхийн сахилгын хороонд 24 хүн нэр дэвшсэнээс 1 хүн нэрээ татсан тул 23 хүнтэй ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулсан.</p>
<p>10</p>	<p>Наймдугаар үе шат Журмын 3.1.8-д заасны дагуу “нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1-д “Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, мөн журмын 12.6-д “Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу саналаа Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай. Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5-“энэ хуулийн 77.4.4-т заасан санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.” гэж заасан. Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, илтгэгч гишүүн бүр өөрсдийн судалсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулж, ажлын хэсгийн бусад гишүүн саналаа хэлж, асуулт асууж хэлэлцсэн. Үүний дараагаар санал хураалтыг нууцаар явуулахад зургаан нэр дэвшигч Ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналыг авсан. Өөрөөр хэлбэл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Ц.Давхарбаяр 11 санал, Д.Ариунтуяа 7 санал, Д.Мягмарцэрэн 7 санал, Д.Эрдэнэчулуун 7 санал, Х.Хашбаатар 6 санал, тус тус авсан.</p>
<p>11</p>	<p>Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь Ажлын хэсэг журмын 7.1-д заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ, мөн журмын 12.4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу явагдсан тухай нэгтгэн дүгнэж бичнэ.</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу сонгон шалгаруулалтын найман үе шат тус бүрийг зохион байгуулсан.</p>
<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ</p> <p>Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан,</p>	

<p>нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.4.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.</p>	
12	<p>Боловсрол Төгссөн их, дээд сургууль, коллеж, боловсролын зэрэг, төгссөн оноор нь хамгийн сүүлийнхээс нь эхлэн дараалуулж жагсааж, журмын 2.1.2, 2.2.2-д заасан шаардлагыг хангаж байгаа нь ямар мэдээлэл, нотлох баримтаар тогтоогдсон талаар бичнэ.</p> <p>1983 он Хэнтий аймгийн Биндэр суманд (бүрэн дунд боловсрол) 1988 он МУИС НУФ хуулийн ангид эрх зүйч дээд боловсрол(бакалавр) 1999 он МУИС (магистр) 2018 он МУИС ХЗС-д хууль зүйн ухаанаар докторын зэрэг хамгаалсан. Эдгээр сургууль төгссөн, боловсрол эзэмшсэн, эрдмийн зэрэг хамгаалсан нь холбогдох эх баримтуудаар баталгаажсан.</p>
13	<p>Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай Журмын 2.1.2, 2.2.2-д заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Хэнтий аймаг, шүүхийн дадлагажих ажилтан - 11 сар - Хууль зүйн яам, Хууль судлалын төвд ажилтан - 3 жил 10 сар - МУИС-ийн Хууль зүйн сургуульд эрдэм шинжилгээний ажилтан - 4 жил 2 сар - МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш - 1998 оноос одоог хүртэл - Улсад 32 жил ажилласан туршлагатай. - Эрх зүйч мэргэжлийн дагуу хашсан алба ажлын хугацаа нь эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг бүрэн хангаж байгаа нь баримтаар баталгаажсан.
14	<p>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p> <p>Хууль зүйн өндөр мэргэшилтэй нь ирүүлсэн материалаас бүрэн нотлогдож байгаа бөгөөд МУИС-д багшаар 27 жил ажиллахдаа хууль зүйн ухаанаар докторын зэрэг хамгаалсан, дэд профессор, эрдмийн зөвлөлийн гишүүн, 50 гаруй эрдэм шинжилгээний бүтээл туурвисан байна. Хууль зүйн салбарт олон шавь төрүүлсэн сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн хүн гэдэг нь ярилцлага, судалгааны явцад тогтоогдсон тул шаардлага хангаж байгаа гэж үзсэн.</p>
15	<p>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p>

	Нэр дэвшигчийн ёс зүй, ажил хэргийн талаар шүүмжлэлтэй болон сөрөг үнэлгээ өгсөн хүн байгаагүй. Хашиж ирсэн албаны шугамаар түүнийг удирдаж байсан, удирдлагад нь ажиллаж байсан, хамт ажиллаж байсан хүмүүс нь бүгд түүнийг өндөр мэдлэгтэй, шударга зан чанартай, ажил хэргийн чадвар сайтай, бусдын нөлөөнд автахааргүй хүн гэж үнэлсэн нь энэ талаар шаардлага бүрэн хангаж байгаа гэж үзэх үндэс болсон.
16	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай Журмын 2.1.3, 2.2.3-д заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж байгааг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Нэр дэвшигч нь төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй нь иргэний бүртгэл мэдээллийн холбогдох баримтуудаар баталгаажсан.
17	Монгол Улсын иргэн мөн тухай Журмын 2.1, 2.2-д заасны дагуу “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа нь иргэний бүртгэл мэдээллийн холбогдох баримтуудаар баталгаажсан.
18	Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай Журмын 2.1.5, 2.2.4-д заасны дагуу “сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй нь ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
19	Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Журмын 2.1.6, 2.2.10-д заасны дагуу “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж байгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй нь Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн бүртгэл мэдээллийн лавлагаагаар баталгаажсан.
20	Сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байсан эсэх тухай Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэхийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байгаагүй нь Монгол Улсын Их Сургуулийн албан ёсны тодорхойлолтоор баталгаажсан.
21	Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Журмын 2.2.6, 2.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй буюу ажиллаж байгаагүй, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.

	Шүүхийн ерөнхий зөвлөлийн орон тооны гишүүнээр ажиллаж байгаагүй болон одоо ажиллахгүй байгаа нь түүний ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
22	Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай Журмын 2.1.4, 2.2.4, 2.2.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байгаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Ажиллаж байгаагүй нь түүний ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
23	Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Шүүхийн тухай хуулийн 95.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Ажиллаж байгаагүй нь түүний ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
24	Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.7-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Ажиллаж байгаагүй нь түүний ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
25	Өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.8-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Ажиллаж байгаагүй.
26	Прокуророор ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь прокуророор ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ. Ажиллахгүй байгаа нь түүний ажил эрхэлж байсан болон одоо эрхэлж байгаа баримтуудаар нотлогдсон.
27	Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь Ажлын хэсэг нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлж журмын 2.1, 2.2, 2.3-д заасан харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хамгийн сайн хангаж буй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ. Нэр дэвшигч Ц.Давхарбаяр 1965 онд Улаанбаатар хотод төрсөн. 1983 онд Хэнтий аймгийн Биндэр суманд ЕБС төгсөн, 1988 онд МУИС (НУФ) хуулийн ангид эрх зүйч мэргэжил эзэмшиж, 1999 онд МУИС-д магистрын зэрэг хамгаалсан, 2018 онд

МУИС-д хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Ажилласан байдал нь Хэнтий аймаг, шүүхэд дадлагажих ажилтан, Хууль зүйн яамны хууль судлалын төвд ажилтан, МУИС-ийн Хууль зүйн сургуульд эрдэм шинжилгээний ажилтан, 1998 оноос одоог хүртэл МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, дэд профессороор ажиллаж байна. Боловсролын салбарт 27 жил ажилласан. 50 бүтээл хэвлүүлсэн, хамт олныхоо дунд нэр хүндтэй, сахилгын зөрчил дутагдал гаргаж байгаагүй байна. Монголын Хуульчдын Холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр ажиллаж байсан, мөн МУИС-ийн Ёс хорооны хурлыг удирдан явуулж ёс зүйн маргааныг шийдвэрлэсэн туршлагатай болно. Нэр дэвшигчийн ирүүлсэн баримт материалуудыг судлан үзээд хууль зүйн өндөр мэдлэгтэй, ур чадвартай, туршлагатай, ёс зүй, зан төлөвийн хувьд Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр ажиллах бүрэн боломжтой гэж ажлын хэсэг дүгнэв.

Хавсралт: тайлан гаргахад тулгуурласан баримт

Дараах баримтыг жагсаан бичнэ: ХЗБХ-д цахимаар болон бичгээр ирүүлсэн 174 хуудас материалыг судлан үзэж итгэгч гишүүний тайланг бичив.

- Ажлын хэсгийн гишүүний тусгай санал;
- нэр дэвших тухай хүсэлт;
- төрийн албан хаагчийн анкет;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;
- эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлох харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;
- эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
- хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт;
- хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээллийн хуулбар;
- холбогдох бусад баримт.